

тийн бүтэц үйлдвэрлэлийн энэхүү өөрчлөлтийг тусгахгүй, хөдөө аж ахуйг эрхлэгчдийн хувь төдийлөн буурахгүй байгаа нь Азийн орнуудын онцлог юм. Ийм учраас хөдөө аж ахуйн секторт хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх нь өөрчлөн байгуулалтын нэг зангилаа асуудал мөн гэж үзэж байна. Мөн үйлчилгээний эзлэх хувийг үйлдвэрлэлийн хэмжээ, ажил эрхлэлтэд аль алинд нь нэмэгдүүлэхийг чухалчилж байна. 80-аад оны эхээр болсон томоохон уналт өөрчлөлтөд тэсэн үлдэсний шалтгааныг хөдөө аж ахуйн секторын хөгжил, гадаад худалдаанаас харьцангуй бага хамаардагаар тайлбарлаж байна.

Өөрчлөн байгуулалтыг амжилттай хэрэгжүүлэхэд зарим нөхцөл бүрдүүлэх шаардлагатай бөгөөд ийм урьдач нөхцөлийн тоонд хөдөө аж ахуйд өөрчлөлт хийх, нөөц ресурсийг дахин хуваарилж түргэн болгох, түүхий эд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний протекционизмыг даван туулж бусад салбартай тэнцвэртэйгээр хөгжүүлэх зэрэг асуудал орж байна.

Хөдөө аж ахуй дахь өөрчлөн байгуулалтад нэг талаас нэмэгдэл (ахиуц) өртөгтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түргэн хөгжүүлэх замаар хөдөө аж ахуйн бүтцийг өөрчлөж агро эдийн засгаас индустрал эдийн засагт шилжих, нөгөө талаас «ногоон хувьсгал» нөлөөлөөгүй, бүтээмж багатай газарт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хурдацыг нэмэгдүүлэхэд төрөөс эрчимтэй оролцохыг ойлгож байна.

ЯПОН БА АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ

(90-ээд он)

О.Оюунгэрэл*

Олон улсын дэг журмын хэм хэмжээ шинэчлэгдэж, урьдын Америк, Зөвлөлтийг голлосон хоёр туйлт системээс олон туйлт систем рүү шилжих үйл явц эхлээд байна. Эдгээр шинэчлэлт өөрчлөлтийн үйл явц Европт эхлэн өрнөж, аажмаар Ази, Номхон далайн бүс нутаг руу шилжин ирж байна. Ази, Номхон далайн бүс нутагт урьд Алс Дорнод гэж нэрлэгдэж байснаа одоо Номхон далайн баруун хэсэг гэгддэг болсон Зүүн Өмнөд Ази, далайн орнууд хамаарна. Уг бүс нутагт амьдрал ахуй, шашин шүтлэг, бичиг үсэг өөр өөр олон үндэстэн оршин суудаг билээ. Тухайлбал, нэг хүнд ногдох үндэсний орлого 23 мянган америк доллар бүхий Япон болон 130 орчим доллар ноогддог Камбож ч хамран орж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийг бүхэлд нь «Дэлхийн аж үйлдвэрийн бааз» болгон хувиргахад Японы аж үйлдвэрийн хөгжил их хувь нэмэртэй билээ.

Япон улс дэлхийн тавцан дээр гарч ирсэн цагаас хойш дипломат бодлогынхоо зарчмыг:

1. НҮБ-ын төвийг сахих бодлогыг баримтлах
2. Дэлхийн чөлөөт улс орнуудтай хамтын ажиллагаа явуулах
3. Азийн орны хувьд энэ бүс нутагт байр сууриа бэхжүүлэх явдал гэж тодорхойлсон.

*ДДОУС-ийн Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Сүүлийн үед Японы байр суурь, түүний эдийн засгийн нөөц бололцоо өндөржиж, олон улсын тавцанд гүйцэтгэх үүрэг, түүнд тавих дэлхий нийтийн найдлага ч өсөн нэмэгдсээр байна. Одоо Япон дэлхийн 7 том гүрний нэг бөгөөд НҮБ-д оруулах хөрөнгөний хэмжээгээр АНУ ын дараа орж, ямар ч буурай орныг дэмжин туслах чадвартай улс болоод байна.

Японы гадаад дахь эдийн засгийн хамтын ажиллагааны хэлбэрийн нэг нь ODA төсөл буюу засгийн газрын хөгжлийн тусламж юм. Энэ төсөл нь хандив, шууд зээл, олон улсын аливаа байгууллагад хөрөнгө оруулах хэлбэрээр явагдах бөгөөд 1990 оны байдлаар хоёр орны хоорон дахь хамтын ажиллагаа нь төслийн 69 хувийг эзлэв.

Бүс нутаг дахь улс төрийн байр сууриа бэхжүүлэх нь Японы хувьд чухал асуудлын нэг, нөгөө талаас Азид давамгайлж буй Японы эдийн засгийн нөлөөлөх хүчин чадал хүчтэй хэвээр байгаатай холбоотой. Учир нь Азид томоохонд тооцогддог аж үйлдвэрүүдийн дийлэнх нь гадаадын хөрөнгө оруулалтын буюу япон гаралтай. Өмнөд Солонгос зэрэг цөөхөн орныг үл тооцон, орон нутгийн, үндэсний бие даасан хөрөнгө капиталтай болсон улс хараахан гараагүй байна. Иймээс 2000 он гэхэд ч, Японы эрдэмтдийн тооцоолж байгаагаар, Ази, Номхон далайн эдийн засгийн бүтцэд онцын өөрчлөлт гарахгүй бөгөөд нөгөө талаар Япон нь Азийн эдийн засгийн хүрээг бүхэлд нь бүрдүүлж, XXI зууныг «Ази, Номхон далайн зуун» болгохыг эрмэлзэж байгаагийн хувьд, тухайн улс орнуудын эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухаан техникийн бүхий л салбарт үзүүлэх туслалцаа дэмжлэгээ өргөжүүлэх хэрэгтэй болоод байна.

Сүүлийн үед Японы засгийн газар Ази, Номхон далайн бүс нутагт эдийн засгийн үйл ажиллагаагаа идэвхжүүлэхийн сацуу улс төрийн байр сууриа бататган бэхжүүлэх талаар янз бүрийн алхам хийж байна. 1991 оны 5 дугаар сард ерөнхий сайд Т. Кайфу Зүүн Өмнөд Азийн орнуудад айлчлах үеэр, Япон улс цаашид Азид улс төрийн хувь нэмэр оруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлэн, Азид явуулах гадаад бодлогын шинэ алхмаа тодорхойлжээ. Японы Ази дахь бодлого агуулгын хувьд гэвэл, Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжиж буй орнуудын эв нягтралыг дээшлүүлэх, олон улсын энх тайвны үйл хэрэгт хувь нэмэр оруулах, Япон-Америкийн харилцааг үндэслэн Камбожийн асуудал зэрэг улс төрийн асуудлыг шийдвэрлэхийн тулд Зүүн Өмнөд Азийн орнуудтай хамтран ажиллаж чадахуйц түнштэй болох зэрэгт чиглэж байна.

Бүс нутаг дахь худалдаа, эдийн засгийн интеграци

Олон ургальч үйл явцыг тусгал болгосон орон нутгийн шинэ дэг журмын нэг нь бол 1989 онд үүссэн АРЕС юм. (Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны зөвлөл). Уг зөвлөл Америк, Канадыг хамарсан өргөн хүрээтэй хэмжээнд Ази, Номхон далайн бүс нутаг дахь ашиг сонирхлыг зохицуулах үүрэгтэй бөгөөд Умард-Өмнийн ялгааг багасгах, чөлөөт худалдааны бүсийг байгуулах гэсэн системийн болон эдийн засгийн төвшний ялгааг давсан, «глобал» шинж чанартай зүйл болоод байна.

Азийн бүс нутагт шинээр бүрэлдэн тогтож буй нөхцөл байдалтай уялдан Зүүн-Өмнөд Азийн орнуудын зүгээс эдгээр улс орны хооронд эдийн засгаар хамтран ажиллах хөдөлгөөн эрчимжиж эхлэв.

1992 оны 1 сард АСЕАН-ны орнуудын тэргүүн нарын зөвлөлгөөн дээр Зүүн-Өмнөд Азийн орнуудын холбооны (АСЕАН) чөлөөт худал-

дааны бүсийн (АФТА) концепцийг албан ёсоор дэвшүүлж санал нэгтгэйгээр баталжээ.

Цаашид чухалчлан гарч ирж байгаа томоохон асуудал бол «их гүрний төвлөрөх үзэл баримтлалд» бус харин орон нутгийн дэг журмыг сахих үзэл юм. Энэхүү үзэл санааг 1990 онд Малайзийн ерөнхий сайд Махатхир ЕАЕС (Зүүн Азийн эдийн засгийн бүс нутгийн концепци) гэсэн хэлбэрээр анх дэвшүүлэн гаргаж ирэв. Ийнхүү «доороосоо» үүсэн гарч ирсэн концепциудын жишээг дурьдахад, нэлээд дээр гарч ирсэн Япон тэнгисийн бүс нутгийн концепци, мөн Индонези, Малайз. Сингапурын гурвалсан хамтын ажиллагааны концепци зэрэг ар араасаа гарч ирж байгаа орон нутгийн үндэсний төвшин дэх концепциуд орно. Тухайлбал, ЕАЕС-ийн цаана гаднын том гүрнүүдийн тусламжтайгаар бус харин уул бүс нутгийн улс орнуудын хоорондох урьдын хамтын ажиллагааны системийг бүрдүүлэх, нэг үгээр хэлэхэд колонийн газар нутаг гэсэн ойлголтоос бүрмөсөн ангижрана гэсэн утга санаа агуулагдаж байх жишээтэй.

Ази, Номхон далайн бүс нутагт хэрэгжүүлэх

японы төсөл

Өнөөгийн нөхцөлд Японы хувьд Ази, Номхон далайн бүс нутагт өөрийнхөө эдийн засгийн хувьд оршин тогтнох байдал, нэр хүнд, хүч нөлөөгөө хамгаалан бэхжүүлж чадах явдал хамгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Сүүлийн үед бүс нутаг дахь асуудалтай холбогдуулан Японы зүгээс Ази, Номхон далайн районд авч хэрэгжүүлэх хэд хэдэн төсөл гараад байна. Тэдгээрийн нэг нь гэхэд Америкийг түшиглэсэн эсвэл Америктай үл хамтран ажиллана гэсэн дөрвөн зүйлт төслийг дурьдаж болно.

А. Америктай

1. Япон, Америк хоёр нь эдийн засгийн нэгдэл холбоогоо улам бүр нягтруулан, тухайн үеэсээ хамааран, хоёр орны хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулж, Япон ба Хойд Америкийн чөлөөт худалдааны бүсийг эдийн засгийн хувьд нэгдмэл болгох. Үүний тулд Япон, Америкийн улс төрийн бодлого, байгуулалт, эдийн засгийн бүтцийг үлэмж жигдрүүлэн нэг төрлийн болгох шаардлагатай.

2. Япон нь Америкийг оролцуулсан хэлбэрээр Ази, Номхон далайн орнуудтай хамтран эдийн засгийн хамтын ажиллагаагаа улам бүр бэхжүүлж, тодорхой үеэс хамааран Номхон далайн орнуудын хүрээнд чөлөөт худалдааны бүс нутгийг байгуулах.

3. Америкийг үл оролцуулах хэлбэрээр Зүүн Азийн бусад оронтой эдийн засгийн хамтын ажиллагаагаа улам бүр гүнзгийрүүлж, бололцооноос хамааран чөлөөт худалдааны бүс нутгийг байгуулах.

4. Ямар ч улс, бүс нутаг ч гэсэн оршин тогтнож байгаагаас илүү олон байгуулалтай хамтын ажиллагааг үл гүнзгийрүүлэн тухайн байдлыг хадгалах.

Эдгээр 4 төслөөс Японы хувьд 2-р төсөл нь хамгийн боломжийн байгаа бөгөөд бусад төслийн хэрэгжилтийг үгүйсгэж болохгүй юм.

Б. «Япон тэнгисийн хүрээн дэх эдийн засгийн бүс нутгийн» концепци

Уг концепцид Оросын Алс Дорнодын хэсэг район, Хятадын Зүүн Хойд зүгийн гурван муж (Хар мөрөн муж, Гирин, Ляонин), Өмнөд Со-

лонгос, БНАСАУ, мөн Япон хамарч байгаа юм. Эдгээр улс Ази тивийн газар нутгийн 20 хувийг, хүн амын 10 орчим хувийг эзэлж, нийт үндэсний орлогоороо 3 триллион доллар орчимд хүрч байна. Энэ бүс нутагт найдвар өндөржиж ирсэн нь Дорно-Өрнийн хоорон дахь хүйтэн дайны үе дуусаж, хурцадмал байдал намжиж мөн Зүүн хойд Азийн улс төрийн уур амьсгал нааштай талруугаа хэлбийж ирэх болсонтой холбоотой аж. Энэхүү бүс нутгийн талаарх концепцийг хэрэгжүүлэхэд японы талаас 3 төсөл боловсруулжээ. Үүнд:

1. Харилцан туслалцах харьцааг хөгжүүлж, шууд хариуцлагатай хөдөлмөр хуваарилалтын эдийн засгийн бүс нутгийг байгуулах

2. Хятад, Оросын нутагт байгуулах угсралтын үйлдвэрээс загас агнуурын салбарт хөдөлмөр хуваарилалтын харилцаа тогтоох хүртэл хөгжих

3. Орос, Хятадын эдийн засгийн бодлого бүтэлгүй болж улс төрийн асуудалд холбогдон орооцолдсоноос уг концепци нь саатан зогсонги байдалд орох

Хятадын хувьд өнөөгийн явуулж буй нээлттэй гадаад бодлогод ч өөрчлөлт гарч болох эсэхийг ч үгүйсгэж болохгүй. Мөн түүнчлэн Япон Оросын хооронд хойд Курилын арлуудын асуудал ч нэг бэрхшээл болоод байна. Уг асуудлыг шийдэхээс нааш Оросод олгох их хэмжээний санхүүгийн тусламж итгэл муутай болж, япон үйлдвэрүүд ч нэг их урагшлан орохыг зорихгүй. Солонгосын хойгийн хувьд, эдийн засгийн бүс нутгийн хүрээнд БНАСАУ ямар хэмжээнд оролцох вэ гэдэг нь хоёр солонгосын яриа хэлэлцээр нааштай явагдах, мөн Япон, Ардчилсан Солонгос улсын хооронд дипломат харилцаа тогтоох тухай гэрээ хэлэлцээрийн явцаас хамаарах болно.

Бүс нутаг дахь аюулгүй байдлын асуудал, Японы байр суурь

Бүс нутгийн хүйтэн дайны төгсгөл рүү чиглэсэн үйл явцын онцлогийг японы тал гол төлөв их гүрнүүд ба бүс нутгийн улс орнуудын хооронд гажууд үзэгдэл үүсэж буйтай холбож байна. Аль ч өөрчлөлтийн үед нэг талаас холбогдол бүхий улс орны санаачилга нь аливаа асуудлыг шийдвэрлэхэд гол үүрэг гүйцэтгэж ирсэн. Гэвч нөгөө талаас, хүйтэн дайны гол хариуцлага хүлээж байсан Америк, Зөвлөлт, Хятад, Япон гэсэн орнууд нь хүйтэн дайны бус зам руу бодлогоо өөрчилж, тааламжтай нөхцөл бүрдүүлснийг нь үгүйсгэж болохгүй билээ. Нөгөөтэйгүүр хүйтэн дайны төгсгөлийг зорьж бүс нутгийн шинэ дэг журмыг тогтоох гэсэн хөдөлгөөн өрнөж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан хуучин Зөвлөлтийн дэвшүүлсэн их гүрнүүдийг төвлөрүүлэн байлгах дэг журмыг дахин бүрдүүлэх гэсэн үйл явц байгаагийн сацуу урьд Малайзаас дэвшүүлсэн ЕАЕС-маягийн бүс нутгийн улс орнуудын дотроос «доороос» бий болгосон дэг журмыг байгуулах хөдөлгөөн үүсээд байна. Эхнийх нь аюулгүй байдлын баталгааг голлосон зүйл байхад, хоёр дахь нь эдийн засгийн ашиг сонирхлын зохицуулалтыг гол тусагдахуун болгож байгаагаараа мэдэгдэхүйц ялгаатай зүйл юм.

Уг бүс нутгийн гадна дотно оршиж буй их гүрнүүд нь гол төлөв дээр дурьдсан олон ургальч үзэл бодлыг тусгал болгосон бүс нутгийн дэг журмыг байгуулна гэж хэт хуучинсаг хандаж байхад бүс нутгийн улс орнууд шинэ дэг журмыг идэвхтэй шаардсаар байна. Ийнхүү янз бүрээр шаардагдаж буй дэг журмыг зөвхөн агуулга төдий биш, мөн хэрэгжүүлэх талаарх мэдэгдэл нь мэдэгдэхүйц ялгаатай байна.

Эл асуудлыг шийдвэрлэхийн тулд Японы тал Ази, Номхон далайн

улс орнуудын хүйтэн дайны байдлаас гарах гэсэн эрмэлзлийг нь хүлээн авч, харин бүс нутгийн хувьд бүх улс орнууд нь тэгш эрхтэй оролцон, ардчиллын байр сууринаас харилцан санал нэгтэй байж чадахуйц арга барилтай байх хэрэгтэй гэж үзэж байна

Япон РКО-д орсон нь

Японы цэрэгжилтийн асуудал, түүний төсөв, зардал сүүлийн үед өсөн нэмэгдэх болсон нь гадаад хүчин зүйлээс ихээхэн шалтгаалж буйг тэмдэглэн хэлэх хэрэгтэй байна.

Персийн булангийн дайн дахь Японы олон улсын хамтын ажиллагааны талаар РКО буюу НҮБ-ын энх тайвныг сахих үйл ажиллагаанд Японоос зохих бие бүрэлдэхүүн илгээх явдал асуудал болж хэлэлцэгдэв. Засгийн газар, Либерал-Ардчилсан Нам нь олон нийтийн санал тогтворгүй буй нөхцөлд «НҮБ-ын энх тайвнаар хамтран ажиллах тухай хуулийн төсөл» боловсруулж, 1990 оны 10 дугаар сард парламентад оруулсан бөгөөд уг хуулийн төсөл нь сөрөг намуудын байр сууринаас шалтгаалан дэмжлэг авч чадаагүй билээ. 1991 оны 9-р сарын 19-нд Засгийн газраас парламентад дээрх зүйлээр шинэчлэн засварласан 2 хуулийн төслийг дэвшүүлэв. Уг төсөлд НҮБ-ын энх тайвныг сахих үйл ажиллагаанд японы өөрийгөө батлан хамгаалах хүчний отрядыг хавсран оролцуулах явдлыг улам идэвхжүүлэхийг шаардсан ба үүнд зөвхөн ажиглагчийн үүрэг гүйцэтгэх төдийгүй мөн энх тайвныг дэмжих хэсэг рүү японы өөрийгөө хамгаалах хүчний бүрэлдэхүүнийг илгээх нь зүй тэй гэж үзжээ. Түүнээс гадна дээрх төсөлд зэвсэглэлийг хэрэглэх явдал нь Үндсэн хуультай үл холбогдохыг хүлээн зөвшөөрөх бөгөөд шаардлагатай үед зэвсэгт хүчнийгээ зөвхөн өөрийгөө хамгаалах зорилгоор хамгийн бага хязгаартай хэмжээнд хэрэглэж болно гэж заажээ. Энэхүү төслийг хэлэлцэх үед зэвсгийг хэрэглэх, зэвсэглэлт үйл ажиллагаанд оролцох талаар маргалдаан үүссэн боловч улс төрийн нэгдмэл санал гарсны үр дүнд 1991 оны 11-р сарын 27-нд шинэ хуулийн засварласан төслийг олонхийн саналаар баталжээ. Удалгүй шинэ хууль хүчин төгөлдөр болмогц японы засгийн газар нь Камбож руу 2 мянга орчим хүний бүрэлдэхүүнтэй цэргийн ажиглагч, мөн өөрийгөө хамгаалах хүчний хэсгийг 1992 оны 9-р сараас 1993 оны 10-р сар хүртэл жил 2 сарын хугацаатайгаар илгээжээ.

Ийнхүү Япон нь НҮБ-ын ЭТСХҮА-нд идэвхтэй оролцох үүргээ биелүүлэх анхны алхмаа хийж эхлээд байна.

Япон дээрх алхам хийх болсонтой холбогдуулан дотоодод нь янз бүрийн үзэл гарч, маргаан үүсдэг боловч улс төрийн зүтгэлтэн, судлаач нарын дийлэнх нь уг байр суурийг Дорно-Өрнийн хүйтэн дайн дууссан өнөө цагт НҮБ-ын дэмжлэгтэйгээр энх тайвныг бэхжүүлэх үйл ажиллагаа боломжтой болсон гэж тайлбарлаж байна.

1993 оны 2-р сарын 6-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бутрос Гали НҮБ-ын төв дээр «Иомиури» сониныхонтой хэвлэлийн бага хурал хийж Японыг НҮБ-ын энх тайвныг сахих үйл ажиллагаанд хамруулан, энх тайвныг бэхжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг шаардаж, зөвхөн эмнэлгийн тусламж, цэргийн хэсэг бүрэлдэхүүн илгээхийг хязгаарлахгүйгээр, ирээдүйд байлдааны бэлтгэл бүхий цэргийн бүрэлдэхүүнтэй байхыг хүссэн байна.

Азийн аюулгүй байдал, түүний түгшүүрийн голомтууд

Азийн аюулгүй байдлын баталгаа тодорхой бус байна. Хэдийгээр уг бүс нутагт шинэ дэг журам аюулгүй байдлын тогтолцоо бүрэлдэж байгаа боловч, энэ талаарх улс хоорондын яриа хэлэлцээ маш дульмаг байна гэж хэлж болно. Японы үзэж байгаагаар ийм дэг журмыг тогтоохын тул юуны өмнө «харилцан ярилцлагыг уламжлалт» зүйл болгох хэрэгтэй.

Хүйтэн дайн төгсгөл болж их гүрнүүдийн харилцаа сайжирсны улмаас Солонгосын хойгийн асуудлаар хэлэлцээр эхлэж Камбож дахь иргэний дайн төгсгөл рүүгээ хандаж байна.

Гагцхүү солонгосын хойгийн асуудал буюу хоёр Солонгос хэдийд ямар хэлбэрээр нэгдэх вэ гэдэг нь одоогоор тодорхойгүй байна. Япон, Хятад зэрэг хөрш зэргэлдээ улс орнууд энэхүү нэгдлийг сайшааж байна уу үгүй юу гэдгийг одоогийн шатанд мэдэхэд хэцүү байна.

Үүнээс гадна Азид буй ил болон далд хурцадмал байдлын гол хүчин зүйлд Япон-Оросын хойт (Курилын) арлуудын асуудал, хойт Номхон далайг голлосон америк-оросын цэргэжилтын систем зэргийг дурьдаж болно.

АСЕАН-ны орнуудын хувьд Америк улс Ази дахь аюулгүй байдлын талбарт өөрийн оролцоогоо багасгаж, харин түүний оронд Япон, Хятад, Энэтхэг зэрэг Азийн нэг гүрэн гарч ирэх гэж байна уу гэсэн түгшүүр буй болоод байна. Түүнчлэн эдгээр орон нь харилцан бие биенээсээ болгоомжлох явдал гарч байна.

Өнөө үед зөвхөн Зүүн-Өмнөд Азийн орон төдийгүй, мөн Хятад, Япон, Энэтхэг зэрэг орныг оролцуулан Ази тив бүхэлдээ цэргийн хүчээ бэхжүүлэн нэмэгдүүлэх хандлагатай байна.

Ази тив дэх аюулгүй байдлын уур амьсгал нь янз бүрээр илэрч байна. Харилцан болгоомжлон сэрэмжлэх явдал нь гол төлөв эсрэг талыгаа эсвэл хэт сайн мэдэх, эсвэл биесээ сайн ойлгож мэдэхгүй явдлаас гарна. Тухайлбал, Америкаас Азийн орон бүртэй хийсэн хоёр талын хэлэлцээрээр бүс нутгийн аюулгүй байдал баталгаатай болж буй нөхцөлд Япон, Өмнөд Солонгос зэрэг хөрш зэргэлдээ орны хувьд аюулгүй байдлын талаар шууд харилцан ярилцлага огт хийгдээгүй байна.

Аюулгүй байдалд холбогдох түгшүүрийн голомт нь мэдээж зөвхөн цэрэгжилтийн асуудлаар хязгаарлагдахгүй. Үүнд үйлдвэрлэлийн хүчин чадал, худалдаа, техник технологи, хүн амын өсөлт, хөдөлгөөн, байгаль орчныг хамгаалах, хар тамхи, хүний эрхийн асуудал зэрэг маш олон зүйлийг хамруулж болно. Улс төрийн систем цэрэг дайны үзэл бодол, байр суурь ч гэсэн чухал хүчин зүйлд орно.

Япон нь Ази тивд улс хоорондын «харилцан ярилцлагыг уламжлал болгох» гэж уриалсан боловч энэ нь одоогоор дэмжлэг аваагүй л байна.

Японы хувьд ийм нөхцөлд хамгийн зөв сонголт бол эдийн засгийн мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар импортын зах зээлийг өргөжүүлэх, техник технологийг шилжүүлэх, хөрөнгийг эргэлтэнд байлгах, хүн солилцоо зэргийг явуулах явдал юм. Ийм маягаар Зүүн Азийн эдийн засгийн жигд хөдөлмөр хуваарилалтыг урагшлуулж, зах зээлийн үндсэн зарчимд тулгуурлан дэлхийд нээлттэй, өсөж хөгжих чадавхи бүхий эдийн засгийн энэ бүс нутагт дэлгэрүүлэх, ингэснээр Япон ч өөрийнхөө оршин тогтнох байдлаа бататгаж чадна гэж үзэж байна.